

ТАНИЛЦУУЛГА

Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний нэг хүнд ногдох хувьсах зардал тооцох журам"-ын тухай

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зорилгоор төрийн болон төрийн бус байгууллагын харьяанд байгуулсан түр хамгаалах байрыг сум, дүүрэг, аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрийн харьяаллаар ажиллуулж байна.

Түр хамгаалах байр нь үйл ажиллагаандаа “Хохирогчийг хамгаалах байрны үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 6040:2019” Монгол Улсын стандарт, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/116 дугаар тушаалаар батлагдсан “Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх журам”-ыг мөрдлөг болгон хэрэгжүүлж байна.

Улсын хэмжээнд 2022 оны байдлаар Түр хамгаалах 17 байр, Нэг цэгийн үйлчилгээний 17 төв үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд нийтдээ 4795 хүн хамрагдсаны 3226 нь хүүхэд, 1569 нь насанд хүрэгсэд байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 35.4-т “Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний зардлыг нэг хүнд ногдох хувьсах зардлын хэмжээгээр тооцох бөгөөд хувьсах зардлыг тооцох журмыг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэж заасныг үндэслэн “Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний нэг хүнд ногдох хувьсах зардал тооцох журам”-ыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны А/150 дугаар тушаалаар баталсан.

Уг журмыг хэрэгжүүлэх явцад “Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив”-ыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/23/27 дугаар хамтарсан тушаалаар баталж хүчирхийллийн хохирогч болсон хүүхдийг гэр бүлээс тусдаа орчинд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний тарифыг шинэчлэн тогтоосон. Иймд түр хамгаалах байрны хамгаалалтад авах хүүхдэд зарцуулах зардлын нормативын давхардлыг арилгах зорилгоор Түр хамгаалах байрны зардлын нийтлэг нормативт өөрчлөлт оруулах шаардлагатай болсон.

Түүнчлэн сүүлийн жилүүдэд тохиолдож байгаа Ковид-19 цар тахал, олон улсад үүсээд байгаа нөхцөл байдал зэргээс шалтгаалсан бараа, ажил, үйлчилгээний үнийн өөрчлөлт нь журмаар тогтоосон хувьсах зардлын тарифыг шинэчлэх зайлшгүй шаардлагыг бий болгож байна.

Дээр дурдсан хоёр үндэслэлээр түр хамгаалах байрны нэг хүнд ногдох хувьсах зардал тооцох журамд дараах өөрчлөлтүүдийг тусгав. Үүнд:

1. Түр хамгаалах байранд байрлах хүүхдэд үзүүлэх хамгааллын үйлчилгээний тариф тусдаа журмаар зохицуулагдах болсон тул давхардлыг арилгах зохицуулалт нэмсэн;
2. Хувьсах зардлын бүрэлдэхүүнд багтахгүй үйлчилгээ, үйл ажиллагааг хэрхэн санхүүжүүлэхийг холбогдох эрх зүйн актыг үндэслэн тодорхой болгосон;

3. Хувьсах зардлын санхүүжилтийг гүйцэтгэлээр санхүүжүүлэх, үйл ажиллагааны онцлог болон бараа бүтээгдэхүүнийг хямд өртгөөр урьдчилан нөөцлөх шаардлагыг харгалзан урьдчилсан санхүүжилт олгох, түүнчлэн төлөвлөснөөс илүү болон дутуу гарсан тооны зөрүүг гүйцэтгэлээр тооцож санхүүжүүлэх зэрэг уян хатан зохицуулалтыг тусгасан;

4. Санхүүжилт олгоход шаардах бичиг баримтын жагсаалтыг тодорхойлж цахим хяналтын тогтолцоо ашиглах талаар шинээр нэмсэн

5. Хохирогчийг нууцалсан кодоор цахим системд бүртгэсний үндсэн дээр санхүүжилт олгох, олгосон санхүүжилтэд хяналт тавих зохицуулалтыг шинээр тусгасан

6. Өмнөх журмын дагуу санхүүжилтийг янз бүрээр ялгаатай тооцож байгааг харгалзан хувьсах зардлын болон санхүүжилтийн хэмжээг хэрхэн тооцох аргачлалыг нэмж оруулсан

7. Түр хамгаалах байран байрласан хохирогчийн хоолны зардлыг хүн өдрөөр харин хувийн ариун цэврийн хэрэгсэл болон нийгмийн ажил үйлчилгээг нэг хүнд нэг удаа олгох багц байдлаар тодорхойлсон нь зардлын хувьд үр ашигтай төдийгүй хувь хүний онцлогт тохирсон сонголтыг бий болгох, шаардлагатай бараа бүтээгдэхүүний нөөц бий бүрдүүлэх боломжтой болсон. Түүнчлэн хувьсах зардлын бүрэлдэхүүнд багтах үйлчилгээг насанд хүрэгч болон хүүхдээр ялгавартай тогтоож өгснөөр хэмнэлт, үр ашгийг бий болгох боломжтой болсон.

8. Бараа үйлчилгээний үнийн өсөлтийг харгалзан хэрэглээний үнийн өөрчлөлтийн статистик мэдээлэлд үндэслэн хоолны зардлын тарифыг одоо байгаа түвшнээс 1.6 дахин, хувь хүний хэрэглээний хувцас, ариун цэврийн хэрэгслийн багц зардлыг 3.6 дахин, холбон зуучлах үйлчилгээний зардлыг 3.7 дахин нэмэгдүүлсэн зэрэг болно.

Журам батлагдсанаар одоогийн мөрдөж байгаа зардлын норматив 40 хувиар нэмэгдэх ба улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа Түр хамгаалах байр, Нэг цэгийн үйлчилгээний төвөөр хамгаалуулах насанд хүрэгчдийн аюулгүй байдлын баталгаа сайжрах болно.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ